



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/73

Биндэр сум

Нийтийн хог цэвэрлэгээний  
ажил зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.6 дахь заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.1, 9.4.4 9.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Биндэр сумын хэмжээнд нийтийн эзэмшлийн газрын хог хаягдлыг цэвэрлэх бүх нийтийн цэвэрлэгээг 2026 оны 05 дугаар сарын 22, 23-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Цэвэрлэгээ явуулах хуваарийг хавсралтаар баталсугай.

3.Сумын төвийн нийтийн эзэмшлийн талбайг хуваарийн дагуу цэвэрлүүлж, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг бүрэн хамруулан ажиллуулахыг Онон багийн Засаг дарга (Б.Тунгалаг), Байгаль хамгаалагч (Н.Болор-Эрдэнэ) нарт даалгасугай.


4.Нийтийн цэвэрлэгээнээс гарсан хог хаягдлыг хогийн төвлөрсөн цэгт тээвэрлэх ажлыг шуурхай зохион байгуулахыг Биндэр Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын дарга (Г.Баярхүү)-д хариуцуулсугай.

5.Цэвэрлэгээний явцад хяналт тавьж, гүйцэтгэлийг хангуулж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Отгонбаяр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ДЭМБЭРЭЛСАЙХАН

  
 Сумын Засаг даргын  
 2026 оны 05 сарын 29-ний өдрийн А/7.3  
 дугаар Захирамжийн 1 дүгээр хавсралт

### НИЙТИЙН ЭДЭЛБЭР ГАЗРЫН ХОГ ЦЭВЭРЛЭХ ХУВААРЬ

№	ХАРИУЦАХ БАЙГУУЛЛАГА	ХОГ ЦЭВЭРЛЭГЭЭ ХИЙХ ГАЗРЫН БАЙРШИЛ	УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛЖ ЦЭВЭРЛЭГЭЭ ХИЙЛГЭХ АЛБАН ТУШААЛТАН
1	ЕБС-ийн багш ажилчид, сурагч нар	Төвлөрсөн хогийн цэг Залуус цэцэрлэгт хүрээлэн	Д. Дамдинпүрэв /ЕБС-ийн захирал/
2	ЗДТГ, Биндэр Нийтлэг ОНӨААТҮГ, Соёлын төв	Өлзий овооноос хойш хогийн цэг хүртэл Хариуцсан ногоон байгууламжын хогийг цэвэрлэх	Г. Өнөболд ЗДТГ-ын Дарга Г. Баярхүү / Биндэр Нийтлэг үйлчилгээний дарга / Г. Дэлгэрмаа / Соёлын төв эрхлэгч /
3	Эрүүл мэндийн төв, Цэцэрлэг	Цагаан хаалганаас Цагаан нуурыг тойроод Хариуцсан ногоон байгууламжын хогийг цэвэрлэх	Ц. Өсөхбаяр / ЭМТ эрхлэгч/ Ж.Үүрцайх / Цэцэрлэгийн эрхлэгч/
4	Биндэр сум дундын ой анги Гутайн даваа хөмүүл голын эхийн БЦГ,	Дармаагийн цээлээс-Хуурай тохой хүртэл Хариуцсан ногоон байгууламжын хогийг цэвэрлэх	О.Сүхбат /Биндэр сум дундын ой ангийн дарга/ М. Хосбаяр / Гутайн даваа хөмүүл голын эхийн БЦГ-ын хууль эрх зүйч/
5	Биндэр Нийтлэг ОНӨААТҮГ	Онон гол дагуу жорлонгийн нүхийг булж даршлах	Г. Баярхүү / Биндэр Нийтлэг үйлчилгээний дарга /

		Хариуцсан ногоон байгууламжын хогийг цэвэрлэх	
6	Ус цаг уурын өртөө, Хаан банк, Төрийн банк, "Сүлдэт-Өндөр" ХЗХ	Шазгайн голын хог / Д. Дугаржавын хойд талаас Х. Ганбаярын дэлгүүр хүртэл Хариуцсан ногоон байгууламжын хогийг цэвэрлэх	Г. Энхмаа /Ус цаг уурын өртөөний дарга/ С. Болорцэцэг /Хаан банкны эрхлэгч/ Г. Гантуяа / Төрийн банкны эрхлэгч/ Г. Баярсайхан / Сүлдэт-Өндөр ХЗХ /
7	Аж ахуй нэгж, байгууллага	50м доторх хог цэвэрлэх	Захиралууд
8	Баг бүрээс 15 хүн	Нийтийн эзэмшлийн талбай	Багийн дарга нар

Хувиар гаргасан:



Б. Тунгалаг БЗД